



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗУРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/50

Алтрага

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 195 дугаар тогтоол, 2022 оны 249 дүгээр тогтоол, Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх зөвлөл, болон үнэлгээний комисс, устгалын комисс, худалдан борлуулах асуудал хариуцсан комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- |                       |  |
|-----------------------|--|
| Зөвлөлийн дарга:      | - Засаг даргын Тамгын газрын дарга   |
| Гишүүд:               | - Санхүүгийн албаны дарга  |
|                       | - Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн  |
|                       | - Хүнс, ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн  |
|                       | - МАА-н үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент, малын үргил бүртгэл, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
|                       | - Мал эмнэлгийн улсын байцаагч   |
|                       | - Хууль эрх зүйн мэргэжилтэн   |
|                       | - Татварын байцаагч  |
| Нарийн бичгийн дарга: | Хэсгийн төлөөлөгч  |

2. Захирамжийн хэрэгжилтийг хуулийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны A/97 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Document-Zahiramg

6729010113